



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 02/30

Жаргалант сум

Эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийг батлах,
хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны 09/30 тогтоолын нэгдүгээр хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР (2026-2028 он)

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Үндэслэл: Монгол улсын Олон улсын гэрээ “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах” тухай конвенц, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол улсын Их хурлын 2021 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2026-2028 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Бүх хайраа гэр бүлдээ” зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан болно. Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн баримжаа олгох болон амьдрах ухаан, эрүүл мэндийн боловсрол, гэр бүлдээ үзүүлэх эерэг нөлөөлөл, манлайллын сургалтад хамруулж, амьдралын чанарыг сайжруулан хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

1.2 ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өнөөгийн нөхцөл байдал: Жаргалант сум нь 3 багтай. 943 өрхийн 3314 хүн амтай. Үүнээс эмэгтэй 1481 буюу 44,6 хувийг эмэгтэй эзэлж байна.

Хөдөлмөрийн насны хүн ам /18-60/-1675 байна. Үүнээс эмэгтэй -805 буюу 48 хувь эмэгтэй эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүйчүүд тоо -126 байгаагаас эмэгтэй 66 байна.

Эмэгтэйчүүдийн статистик тоон үзүүлэлт

№	Статистик тоо												
	Хөдөлмөрийн насны иргэдийн тоо		Ажил хөдөлмөр эрхлэлт тоо		Бүртгэлтэй ажилгүйчүүд тоо		ХБИ өрх тоо	ХБИ тоо		0-18 насны хүүхэдтэй ӨТ эцэг/эх	Хагас өнчин хүүхэд	Бүтэн өнчин хүүхэд	
эм	хувь	Эм	хувь	эм	хувь	эм		хувь	Эх				Эцэг
1	1675		446		126		111	159		28	4	30	6
2	эм	хувь	Эм	хувь	эм	хувь		эм	хувь				
3	805	48%	289	64%	66	52%		60	37%				

Статистик тоо							
Малчин Өрхийн тоо		Тариаланч өрх		Залуу гэр бүлийн өрхийн тоо		1-р одонтой эхийн тоо	2-р одонтой эхийн тоо
526		284		348		212	266
Эмэгтэй малчин өрх	хувь	Эмэгтэй тариалан ч өрх	хувь	хувь	36%		
438	83,26%	132	46%				

№	Төрийн албан хаагчийн статистик тоо											
	200											
1	Цэцэрлэг		Сургууль		Эмнэлэг		ЗДТГ		Жаргалант ус		СМТ	
2	29		63		21		55		27		5	
3	Э М	хувь	ЭМ	хувь	ЭМ	хувь	ЭМ	хувь	Э М	хувь	ЭМ	хувь
4	2 3	79%	49	77%	19	90%	32	58%	5	18,5%	3	60%

Орхон аймгийн хэмжээнд явуулсан судалгаагаар 2024 онд 533 гэрлэлт бүртгэгдсэн бол, гэр бүл цуцлалт 229 байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 181 гэрлэлт бүртгэгдэж, гэр бүл цуцлалт 119 байна. Гэрлэлт цуцлуулж буй хугацааг харахад 10-19 жилийн хамтын амьдралын түүхтэй гэр бүлийн цуцлалт хамгийн өндөр буюу 44.9 хувийг эзэлж байна.

Өрх толгойлсон 0-18 насны хүүхэдтэй эцэг эх 1219, эцэг нь 190, эх нь 1029, бүтэн өнчин хүүхэд 117, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн бүхий гэр бүл 60, архины хамаарал бүхий гэр бүл 347, хүчирхийлэлтэй гэр бүл 220 гэсэн судалгаа гарсан байна.

Эмэгтэйчүүдийн дунд явуулсан судалгаагаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмэгтэйчүүдийн дуу хоолойг орон нутгийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хүргэх, эрүүл мэнд болон амьдрах ухаан, сэтгэл заслын сургалтад хамрагдах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, ядуурал, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, эмэгтэйчүүдийг хөгжихөд чиглэгдсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага байна.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог ханган, эмэгтэйчүүдийн эрүүл амьдрахуйн хандлага, мэдлэг, чадварыг сайжруулан, гэр бүл, нийгэмд эерэг харилцаа, дадлыг төлөвшүүлж, тэдний хөгжил, манлайллыг нэмэгдүүлэхэд оршино.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

Зорилт 3.1 Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн судалгаа, сургалт, нөлөөллийн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэх замаар тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт 3.2 Эмэгтэйчүүдийн нийгмийн манлайллыг нэмэгдүүлж, өрх гэрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар мэдлэг олгох, эрүүл амьдралын дадал бий болгох.

Зорилт 3.3 Эмэгтэйчүүдэд эерэг хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх.

**ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Зорилт 4.1 Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн судалгаа, сургалт, нөлөөллийн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэх замаар тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1.Эмэгтэйчүүдийн талаарх нарийвчилсан судалгаа хийх ажлыг зохион байгуулж, нийгмийн харилцаанд оролцож байгаа эмэгтэйчүүдийн тоон мэдээллийг нэгтгэх, боловсруулах, мэдээллийн сан бүрдүүлэх

4.1.2.Амьдрах ухааны ур чадвар олгох, амьдралын зөв дадал хэвшил, эерэг хандлага төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах

4.1.3.Хувь хүний хөгжил, манлайлал, харилцаа хандлага, сэтгэл зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, тэдний нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэх

4.1.4.Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах

4.1.5.Гэр бүлээрээ дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх товлोलт үзлэг, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлыг сурталчлах, дадлыг төлөвшүүлэх

Зорилт 4.2 Эмэгтэйчүүдийн нийгмийн манлайллыг нэмэгдүүлж, өрх гэрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар мэдлэг олгох, эрүүл амьдралын дадал бий болгох зорилтын хүрээнд

4.2.1.Эмэгтэйчүүдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэнийг дэмжиж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд таниулах.

4.2.2.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах

4.2.3.Нийгэм дэх манлайлагч, олны танил эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн хүмүүсийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх

4.2.4.Бүх түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зохистой бодлого, хэрэгжиж болох хууль, дүрэм журам, шийдвэрийг танилцуулах

4.2.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах,энэ чиглэлээр сургалт, мэдээлэл өгч гэр бүлийн хүчирхийллийг бууруулах

Зорилт 4.3 Эмэгтэйчүүдэд эерэг хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх

4.3.1. Өрхийн үйлдвэрлэл эрхэлж, өөрөө өөртөө ажлын байр бий болгож байгаа эмэгтэйчүүдийг өрхийн үйлдвэрлэл явуулах ажлын байраар хангах, санхүүгийн болон тоног төхөөрөмж, бүх талын дэмжлэг үзүүлэх

4.3.2. Эмэгтэйчүүдийг төсөл боловсруулах, өрхийн санхүүгээ зөв хөтлөх, санхүүгийн боловсролын зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

4.3.3. Эмэгтэйчүүдийн сэтгэлзүйн аюулгүй байдлыг бий болгож, авьяас чадварыг нээн илрүүлж, мэргэжлийн сургалтад хамруулж, өөрийн орлоготой, тогтвортой ажилтай болох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх

4.3.4. Өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй, гэртээ хүүхдээ асардаг эмэгтэйчүүдийн санхүүгийн орлоготой болох олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, хөнгөлөлттэй зээл тусламж үзүүлэх хөтөлбөрт хамрагдахад зуучлах.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2026-2028 онд 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна.

6.1.1. Орон нутгийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрт эмэгтэйчүүдийн талаарх нарийвчилсан суурь судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн нэмэлт заалт оруулсан байна.

6.1.2. Шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэж, эмэгтэйчүүдэд ээлтэйгээр шийдвэрлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан байна.

6.1.3. Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл, тусламж, хөтөлбөрт хамрагдах эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна.

6.1.4. Гэр бүлийн хүрээнд жендэрийн эрх тэгш байдлын талаар мэдлэг мэдээлэл нэмэгдсэн байна.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сумын ЗДТГ, Сумын эмэгтэйчүүдийн зөвлөл хариуцна.

7.2. Нутгийн удирдлагын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, бусад байгууллагууд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

7.3. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр сумын Засаг даргаар батлуулна.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ.

8.1.1. Орон нутгийн төсөв

8.1.2. Орон нутгийн хөгжлийн сан

8.1.3. Хандив тусламж

8.1.4. Бусад эх үүсвэр зэрэг санхүүжилттэй байна.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгаас шаардагдах хөрөнгийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж санхүүжүүлнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛТ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнана:

9.1.1 Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрээр гарган тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын ИТХ-д өргөн мэдүүлж тухайн оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнаж, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна.

9.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

АРАВ.БУСАД

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны
09/20 тогтоолын хоёрдугаар хавсралт

**“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2026 ОНД ХЭРЭГТЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Санхүүжилт		Хариуцан хэрэгжүүлэгч
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин (2026 он)	Санхүүжилт сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	
1	Зорилт 1: Эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэсэн судалгаа, сургалт, нөлөөллийн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэх замаар тэдний хөгжил, оролцоог нэмэгдүүлэх	1.1 Эмэгтэйчүүдийн чиглэлээр нарийвчилсан судалгаа авч боловсруулах ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоо	Тоон үзүүлэлт	2025	Нарийвчилсан судалгаа, тоон мэдээлэл хомс	Нарийвчилсан судалгаа, тоон мэдээллийн сан бий болсон байна.	-	-	ЗДТГ Эмэгтэйчүүдийн зөвлөл
2		1.2 Хүчирхийлэлд өртөж байгаа, амьдралын хүнд нөхцөлд байгаа, архинд донтох эмэгтэйчүүдийн	Сургалт нөлөөллийн ажлын тоо	Тоон үзүүлэлт Тайлан	2025	Судалгаа, тоон мэдээлэл хомс. Сургалт, нөлөөллийн ажлын хүртээмж бага	Эмэгтэйчүүдийн талаарх судалгааны бааз бий болж баяжуулалт хийсэн байна.	3,0 сая	ОНХС	ЗДТГ Эмэгтэйчүүдийн зөвлөл Цагдаагийн хэсэг

7	1.7 Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, түүний ач холбогдлыг сурталчлах, дадлыг төлөвшүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Арга хэмжээнд хамрагдсан гэр бүлийн тоо	Тайлан Тоон мэдээлэл	2025	Мэдээлэлгүй байна	Эмэгтэйчүүдийн мэдлэг мэдээлэл сайжирсан байна.	-	-	ЗДТГ Эмэгтэйчүүдийн н зөвлөл ЭМТ
8	1.8 Өсвөр насны охид болон эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, аян өрнүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Арга хэмжээнд хамрагдсан гэр бүлийн тоо	Тайлан Тоон мэдээлэл	2025	2 удаа зөвхөн эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүд хамрагдсан үзлэг зохион байгуулагдсан.	Үзлэг аянд хамрагдсан хүний тоо	-	-	Эмэгтэйчүүдийн н зөвлөл ЭМТ ТББ
9	1.9 "Хөдөлгөөнөөр эрүүлжье" явган алхалтын арга зохион байгуулах, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Арга хэмжээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Тайлан Тоон мэдээлэл	2025	Мэдээлэлгүй байна.	Эмэгтэйчүүдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх идэвх санаачилга нэмэгдэнэ.	-	-	Эмэгтэйчүүдийн н зөвлөл ЗДТГ ТББ
10	Зорилт 2: Эмэгтэйчүүдийн нийгмийн	Дэмжиж хамтран ажилласан	Тайлан Тоон	2025	Мэдээлэлгүй байна.	Дэмжиж хамтран ажилласан	-	-	Эмэгтэйчүүдийн н зөвлөл

	манлайлыг нэмэгдүүлж, өрх гэрт жөндөрийн хэвшмэл ойлголтын талаарх мэдлэг олгох, эрүүл амьдралын дадал бий болгох	ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэнийг дэмжиж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд таниулах.	байгууллагын тоо Арга хэмжээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	мэдээлэл	-	-	байгууллагын тоо	ЗДТГ ТББ
11	2.2 Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр сурталчлах, үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх	Хөтөлбөр сурталчилсан тоо Хандалтын тоо	Тайлан Тоон мэдээлэл	-	-	-	Хөтөлбөр сурталчилсан тоо Хандалтын тоо	Эмэгтэйчүүдийн зөвлөл ЗДТГ
12	2.3 "Төрийн байгууллагын эмэгтэйчүүдийн манлайлал" сургалт зохион байгуулах	Сургалтын тоо Хамрагдсан төрийн албан хаагч	Тайлан	2023	Нийт төрийн албан хаагчид хамрагдаж байсан.	-	Сургалтад төрийн байгууллагын эмэгтэйчүүдийн 70-аас доошгүй хувийг хамруулсан байна.	ЗДТГ Эмэгтэйчүүдийн зөвлөл
13	2.4 Шинэчилсэн хөдөлмөрийн тухай хуулиас эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх, ажлын байрны баталгааг хангах зэрэг холбогдох зүйл	Сургалтын тоо Дотоод журамдаа тусгасан байгууллагын тоо	Тайлан	-	-	-	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамдаа тусгасан байна.	ЗДТГ Эмэгтэйчүүдийн зөвлөл Сумын нийгмийн ажилтан

		заалтуудаар сургалт хийх, мэдээллээр хангах									ХХУГ
14	Зорилт 3: Эмэгтэйчүүдэд зэрэг хандлагыг төлөвшүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх	3.1 Бизнес эрхлэгч, тариаланч, малчин эмэгтэйчүүдийн уулзалт, хэлэлцүүлэг, өдөрлөг, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах	Зохيون байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан тоо	тайлан	-	-	Тодорхой шийдвэр, зөвлөмжүүд гарсан байна.	ОНТ	Эмэгтэйчүүдийн зөвлөл Сумын нийгмийн ажилтан ХХУГ Багуудын ажлын алба	ХХУГ	
15		3.2 Мэргэжил олгох сургалтуудад хамруулахад зуучлах	Мэргэжил олгох сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	Тоон үзүүлэлт	-	-	Эмэгтэйчүүд мэргэжил олгох сургалтад хамрагдсан байна.	-	Эмэгтэйчүүдийн зөвлөл Сумын нийгмийн ажилтан Багуудын ажлын алба	Эмэгтэйчүүдийн зөвлөл ХХУГ	

16		3.3 Гар урлал, оёдол сонирхогч иргэдийн үйл ажиллагааг дэмжих, үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад хамтран ажиллах	Дэмжиж ажилласан иргэдийн тоо	Тайлан	2025	1 удаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан.	Үзэсгэлэн худалдаа өргөжсөн байна.	-	-	ЗДТГ ХХУГ Эмэгтэйчүүдийн зөвлөл Сумын нийгмийн ажилтан Багуудын ажлын алба
17		3.4 Хүүхэд хамгаалал, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үр хүүхдээ зөв шударга хүмүүжүүлэх, гэр бүл төлөвлөлт, сэтгэл зүйн үйлчилгээг өргөжүүлэх олон талт ажиллагааг зохион байгуулах	Зохин байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан тоо	Тайлан	-	-	Эмэгтэйчүүдийн мэдээлэл сайжирсан байна. Сумын нийт эмэгтэйчүүдийн хувийг хамруулсан байна. Тодорхой шийдвэр, зөвлөмжүүд гарсан байна.	2,0 сая.	ОНХС	ЗДТГ Эмэгтэйчүүдийн зөвлөл Сумын нийгмийн ажилтан ХХУГ Багуудын ажлын алба Цагдаагийн хэсэг

Нийт төсөв: 10 сая төгрөг